



**Өөрийгөө бусдад
танилцуулъя.**

Монгол хэл
6-р анги
Хичээл №1-2





1. Чи бусадтай юугаараа ижил, бусдаас юугаараа ялгаатай гэж бодож байна вэ? Жагсаан бичээрэй.



Ялгаатай тал

Ялгаатай тал

Ижил тал

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....



Нэгэн сурагчийн бичсэн өөрийгөө танилцуулж бичсэнийг уншаарай.

1. Утгыг нь мэдэхгүй үгийг дэвтэртээ бичээд, толь бичиг ашиглан утгыг нь тайлбарлаж бичээрэй.
2. Тухайн үгээ оруулан 2,2 өгүүлбэр зохиогоорой.

Би хэн бэ?

Би хэн бэ? Бусдаас юугаараа давуу юм бол? Сул тал минь юу вэ? Хэн нэгнээс ялгарах ямар онцлог байна? гэсэн асуултад хариулж, өөрийгөө олох гэж их удаан бодсоон.

Харин нэг зүйлийг их гайхсан. Хэн билээ гэдгээ мэдээгүй байж яаж өнөөдрийг хүртэл өөрийгөө би гэж бодож явсан юм бол оо? Яагаад гэвэл би найзаа, ангийнхнаа, багшийгаа, бас гэрийнхнээ тодорхойлж, зан аашийг нь сайн мэддэг хэрнээ өөрийнхөө тухай юу ч мэддэггүй юм билээ.

Тэгээд л би өөрийнхөө эрэлд гарсан. Харин өөрийгөө өөрийнхөө дотроос олсон. Тэгсэн чинь өнөөгийн "БИ" миний дотоод ертөнц дэх "БИ" хоёр огт өөр байсан. Гаднаа их хатуу чанга хүн шиг байдагч бодит амьдрал дээр хатуухан шүүмжлэл сонсоод нүдээ улайтал уйлчихдаг, амархан гомддог, хүний үг даадаггүй хариугүй амьтан байх юм. Өөртөө итгэлтэй, зоригтой юм шиг хэрнээ шинэ хүмүүс, шинэ орчноос айдаг, тэднээс зугтдаг, бүрэг ноомой нэгэн байна лээ.

Амжилт алдар нэрд дуртай мөртлөө олны хараанд байхаас цэрвэдэг, гэртээ ганцаар байх дуртай жожигдуу охин юм уу даа? Бас их хувирамтгай, ихийг санаж сэддэг, зорилготой боловч тэр бүхнээ чаддаггүй юм шиг. Тэгэхээр би дутагдалтай, өөрөө өөртэйгөө зөрчилдөж явдаг нэгэн байж таарах нь.

Бод доо. Зөрчилдөөн юунд хүргэдгийг? Ялагдал, ялалтын алинд нь ...? Иймээс би өөрийгөө таньж мэдэхэд хугацаа гаргая. Өөрийнхөө төлөө өөртэйгөө нэгдэн урагш алхъя гэж шийдсэн.

Та бүхэн ч бас өөрийнхөө хэн гэдгийг таньчхаад, өөрийнхөө замыг бүтээгээрэй. Амжилт хүсье.

Э. Гэрэлсайхан

Би энэ үгийг ийм утгатай гэж бодож байна.

.....
.....
.....
.....
.....


Эхэд

.....
.....

.....асуудал
дэвшүүлсэн гэж
бодож байна.



Сурах бичгийн хуудас 6-аас “1. Инээд муут”, 7-оос “2. Би шувуу сонирхдог” эхүүдийг уншаарай. Тэгээд сурах бичгээс уншсан 2 эх, “3. Би хэн бэ?” гэсэн 3 эхийн ижил ба ялгаатай талыг бичээрэй.



Econtent.edu.mn
сайтаас 6-р ангийн
монгол хэлний сурах
бичгээ авч ашиглаарай.



Уншсан 3 эхийнхээ утга, бүтцийг задлан шинжилцгээе. Тэгэхдээ дараах бүтцийг ашиглаарай.

Инээд муут

Догол мөрийн дугаар	Догол мөрийн санаа
1-р догол мөр	Өөрийнхөө нэрний учрыг танилцуулсан.
2-р догол мөр	

Би шувуу сонирхдог

Догол мөрийн дугаар	Догол мөрийн санаа

Догол мөр гэж юу вэ?

Нэгэн цогц санаа буюу нэг хэрэг явдлын тухай өгүүлсэн нэг ба хэд хэдэн өгүүлбэрийг цогцолбор гэнэ. Цогцолборыг бичигт догол мөрөөр илэрхийлж бичнэ.


Би хэн бэ?

Догол мөрийн дугаар	Догол мөрийн санаа



Асуултад хариулаарай.

- 3 сурагч өөрсдийгөө танилцуулахдаа өөрийнхөө юуг илүү онцолж танилцуулсан байна вэ?
- Чамд дээрх 3 эхийн аль нь илүү таалагдсан бэ? Яагаад?
- Дээрх 3 эхээс чи юуг илүү ухаарч ойлгосон бэ? Яагаад? (Чухал санагдсан үг, өгүүлбэрээ сонгон тайлбарлаж болно.)
- Чи өөрийгөө танилцуулах бол юугаа илүү онцолж харуулъя гэж бодож байна вэ? Үүний тулд оюуны зураглал хийгээрэй. Жишээ нь:





Гэртээ

Өөрийн танилцуулгадаа оруулах материал цуглуулж ирэх

- *Шувуунд дуртай миний найз*
- *Алаг шаазгай орон дээр суугаад жир жир” эхүүдийг уншиж ирэх*
- *Дотны хүмүүсээсээ өөрийнхөө тухай асууж, бичиж, тэмдэглэж ирэх*

